



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Санхүүгийн дотоод аудит

Хамрагдсан байгууллага: Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газар

Тайлангийн код: ХШҮДАГ-2025/ДА/22

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР1

1.ТАНИЛЦУУЛГА.....2

1.1. Байгууллагын тухай2

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ3

2.1. Аудитын зорилго:.....3

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт.....3

2.3. Аудитын арга, аргачлал3

2.4. Өмнөх шалгалтын талаар4

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ.....4

3.1. Засаглалын удирдлагын талаар4

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар.....4

3.3. Дотоод хяналтын талаар.....5

4. Санхүүгийн үйл АЖИЛЛАГААНЫ талаар.....5

5. АУДИТЫН ҮР ДҮН.....7

5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар.7

5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.....7

5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр9

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....9

7. ЗӨВЛӨМЖ.....9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХШҮДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1. ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын дэргэдэх “Дотоод аудитын хорооны 2025 оны төлөвлөгөө”, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталсан “Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн ХШҮДАГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, гэрээт дотоод аудитор О.Пүрэвсүх нар Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газар нь Чойбалсан хотын хорооны товчооны 1947 оны 4-р сарын 16-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор аймгийн биеийн тамирын зөвлөл нэртэй А.Түдэвдагва даргатай 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсанаар Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын анхны үндэс суурь тавигдсан юм. Одоо аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар нь Б.Чимэддорж даргатай 21 хүний бүрэлдэхүүнтэй төрөөс баримтлах бодлого, Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр, аймгийн Засаг даргын шийдвэр, бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, зааврыг мөрдлөг болгон үйл ажиллагаагаа явуулж байна.

Засгийн газар, салбарын яам, аймаг орон нутгийн бодлого шийдвэртэй уялдуулан Биеийн тамир, спорт, идэвхтэй хөдөлгөөнөөр иргэдийн эрүүл мэндийг бэхжүүлэх, спортоор тогтмол хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлэх, тамирчдын спортын амжилтыг олимп, тив, дэлхийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тус байгууллага нь Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/09 дүгээр захирамжаар бүтэц орон тоог 21 ажилтантай байхаар шинэчлэн батлуулсан.

Байгууллагын регистрийн дугаар 9030719, үндсэн үйл ажиллагааны 100070034010, нэмэлт санхүүжилтийн 100070034410, орон нутгийн төсвөөс санхүүжих 100070035009 тоот харилцах дансаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аймгийн Засаг даргын 2009 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 10 дугаар захирамжаар Б.Чимэддоржийг Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын албан тушаалд томилсон байна. Аудитын хамрах хугацаанд дээрх шийдвэрийн дагуу нэгдүгээр гарын үсгийг Б.Чимэддорж одоог хүртэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогчоор 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар томилогдсон Б.Зул нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны хагас болон III улирлын санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

Бүтэц зохион байгуулалт

Байгууллага нь захиргаа аж ахуй - 13, спортын хэлтэс - 7, нийтийн биеийн тамирын хэлтэс - 1 орон тоотой, 3 нэгжтэй ажиллаж байна.

Засаглах удирдлага: Аймгийн Биеийн тамир, спортын газрын даргын тушаалаар 3 зөвлөл ажиллаж байна. Үүнд: 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/75 тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”, 2024 оны 05 дүгээр сарын 08-ны А/31 тушаалаар “Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай” 2024 оны 01 дүгээр сарын 02-ны А/03 тушаалаар “Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комисс” тус тус байгуулагдсан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны III улирлын байдлаар тасалбар болгон санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-нд байдалд санхүүгийн дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүгийн аудит хийж “Өөрчлөлтгүй дүгнэлт” өгсөн тул уг тайлангийн хамарсан хүрээгээр энэхүү хяналт шалгалтыг хязгаарлаж, итгэл хүлээлгэсэн болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Нийтийн биеийн тамирын тухай хууль;
- ✓ Биеийн тамирын тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Аудитын дүнгээр 2 нэр төрлийн алдаа зөрчил илэрч албан шаардлага хүргүүлсний хэрэгжилтийг хянахад 100 хувьтай байна. Үүнд:

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн мян төг	Хэрэгжүүлсэн байдал
Албан шаардлага	2023 оноос үүссэн авлагатай байна.	1,800.0	Аймгийн Засаг даргын 2023 оны А189 дүгээр захирамж "Хүн болох багаасаа" хүүхдийн спортын төслийн дэд ажлын хэсгийн шийдвэрээр "Алтан талын хийморь" ХХК-аар 1,800.0 мянган төгрөг үнэ бүхий гэрлэн хаяг хийлгэхээр гүйцэтгэгч компанируу төлбөрийг шилжүүлсэн боловч хугацаандаа гүйцэтгэж дуусаагүй байсан. Албан шаардлагын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж авлагыг энэ оны 6 сард барагдуулсан.
Албан шаардлага	Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 160.0 хувиар тооцон олгосон.	1,323.9	1,2 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг олгосон ба балансын урамшуулал олгоогүй.
Дүн		3,123.9	

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

3.1. Засаглалын удирдлагын талаар

Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/19 тушаалаар "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг баталсан байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2025 оны эхний улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр "А" индексийн 45, боловсон хүчний чиглэлээр "Б" индексийн 15, нийт 60 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор ерөнхий 3 асуултын хүрээнд 7 дэд асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь "Давтамжтай буюу 2-р түвшин"-нд байна

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь "Эхлэлийн буюу 1-р түвшин"-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Дотоод хяналтын тухайд байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ төлөвлөсөн. Дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төсвийн төлөвлөлт

Байгууллагын 2025 оны төсвийн төслийг 2,829,967.5 мянган төгрөгөөр боловсруулан ССАЖЗЯ - нд хүргүүлсэн.

ССАЖЗЯ - аас тус байгууллагын 2025 оны төсвийг 954,705.3 мянган төгрөгөөр анх баталсан боловч 2025 оны 7 дугаар сард хийгдсэн төсвийн тодотголоор 859,582.5 мянган төгрөг болж 95,122.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус байгууллагын 2025 оны урсгал санхүүжилтэд улс, орон нутгийн төсвөөс 1 хөтөлбөр 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 859,582.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

- Үндсэн үйл ажиллагааны зардалд 693,005.9 мянган төгрөг
- Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардалд 901.7 мянган төгрөг
- Байр ашиглалтын зардалд 187.5 сая төгрөг
- Засаг даргын дэмжлэг 637.7 сая төгрөг

Тус байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 239,361.1 мянган төгрөгөөр буюу 6.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	191,111.9	191,111.9
Авлага	2,200.0	0	-2,200.0
Бараа материал	291,063.2	196,905.6	-94,157.6
Үндсэн хөрөнгө	3,293,471.6	3,438,078.4	144,606.8
Нийт хөрөнгө	3,586,734.8	3,826,095.9	239,361.1
Богино хугацаат өр төлбөр	400	0	-400.
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,586,334.8	3,826,095.9	239,761.
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,586,734.8	3,826,095.9	239,361.1

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 191,111.9 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 94,157.6 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 50,502.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 146,625.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,438,078.4 мянган төгрөг болж 144,606.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант хугацааны 210,853.7 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө орлого авч, тайлант хугацаанд 43,316.5 мянган төгрөгийн цэвэр элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,826,095.9 мянган төгрөг болж, 239,761.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2025 оны III улиралд улс, орон нутгийн төсвөөс 543,753.8 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харуулав.

Байгууллагын 2025 оны III улирлын байдлаарх төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүн

№	Орлого, зардлын эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
I	НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	859,582.5	543,753.8	315,828.7	63.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	798,457.8	492,611.1	305,846.7	61.7
82115	Идэвхитэй амьдралын хэвшлийг дэмжих	20,283.0	20,203.0	80.0	99.6
82116	Үндэсний тэмцээн, наадмын үйл ажиллагаа	39,939.9	30,038.0	9,901.9	75.2
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	901.8	901.7	0.1	100.0
II	НИЙТ ЗАРДАЛ	859,582.5	543,753.8	315,828.7	63.3
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл ура	594,941.1	428,473.1	166,468.0	72.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатга	74,386.7	53,825.8	20,560.9	72.4
210301	Гэрэл, цахилгаан	0.0	0.0	0.0	
210302	Түлш, халаалт	0.0	0.0	0.0	
210303	Цэвэр, бохир ус	0.0	0.0	0.0	
2106	Эд хогшил, урсгал засварын зар	0.0	0.0	0.0	
2104	Хангамж бөраа материалын зардал	9,151.4	3,812.7	5,338.7	41.7
210401	Бичиг хэрэг	1,436.6	949.7	486.9	66.1
210402	Тээвэр, шатахуун	540.0	540.0	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэт	2,990.0	888.4	2,101.6	29.7
210405	Хог хаягдал	1,196.8	640.0	556.8	53.5
210404	Ном, хэвлэл	0.0	0.0	0.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,988.0	794.6	2,193.4	26.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	0.0	0.0	
210702	Дотоод албан томилолт	2,105.6	2,105.6	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	12,337.1	4,309.9	8,027.2	34.9
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	2,217.6	2,217.6	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	796.3		796.3	0.0

210804	Тээврийн хэрэгслийн татвар	99.9	69.0	30.9	69.1
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	69.7		69.7	0.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,963.5	225.5	1,738.0	11.5
210807	Газрын төлбөр	7,190.1	1,797.8	5,392.3	25.0
210901	Бараа үйлчилгээний бусад зарда	60,306.9	50,325.0	9,981.9	83.4
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах тэтгэмж	105,451.9	0.0	105,451.9	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал, шагнал урамшуулал	901.8	901.7	0.1	100.0

5. АУДИТЫН ҮР ДҮН

5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар.

Илэрсэн асуудал 1. Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.	
Дотоод аудитын хамарсан хүрээ: Засаглал, эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үр нөлөөг үнэлэх.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.	Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу удирдамж батлан хяналт шалгалтыг гүйцэтгээгүй, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна;
Шалтгаан	
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө	
Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх.	
Дүгнэлт:	
Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв санхүүгийн зарцуулалтад удирдамжийн дагуу дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.	
Зөвлөмж:	
1. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан, тайлангаар илэрсэн алдаа дутагдлыг залруулан, үр дүнг хамт олонд мэдээлж байх;	

5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.

Илэрсэн асуудал 1. Албан томилолтыг анхан шатны баримт бүрдэлгүй олгож хаасан байна.	
Дотоод аудитын чиглэл: Батлагдсан төсвийн хүрээнд албан хаагчийн томилолтыг олгох, анхан шатны баримт бүртгэл хөтлөлтийг хянаж үр нөлөөг үнэлэх.	
Нөхцөл байдал: Монгол Улсын начин Д.Цогзолдоржийн нэрэмжит Үндсэний бөхийн барилдаан 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж гарын даа, цолчин засуулын ажил гүйцэтгүүлэхээр Д.Мөнхбаяр, Д.Өнөржаргал нарыг томилолтоор ажиллуулахаар явуулсан байна. Тус албан хаагчид томилолтоор ажилласан тухай томилолтын хуудасгүй, ажлын тайлангүй, тооцоо бодсон актгүй 800.0 төгрөгийн томилолт олгогдсон байна.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Албан томилолтын зардлыг бүртгэх, албан хаагчдад олгоходоо Засгийн газрын 1995 оны 218-р тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчдад нөхөн төлбөр олгох журам”, Сангийн сайдын “Зардлын хэмжээг шинэчлэн	Байгууллагын даргын баталсан томилолтын үнэмлэх, удирдамжийн дагуу томилолт олгон, томилолтоор ажиллаж ирсэний дараа ажлын 5

тогтоох тухай” 2011 оны 132 дугаар тушаалыг мөрдөнө. Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журамд заасны дагуу 2.6. Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчид томилолтоор ажиллуулах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр, батлагдсан зардлын төсвийг үндэслэн томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг урьдчилан олгоно. 2.7. Төрийн албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр томилолтын удирдамж, төлөвлөгөөнд заасан үүргээ биелүүлээгүй бол томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийг бүрэн, эсхүл тодорхой хувийг түүний шууд захирагдах нэгжийн удирдлагын саналыг үндэслэн буцаан төлүүлж болно.	хоногийн дотор ажлын үр дүнгийн тайлан бичүүлэн байгууллагын даргаар дүгнүүлж, тэмдэгээр баталгаажуулах ба томилолтоор ажилласан календарийн бүх хоногийн тоог гаргахдаа явсан буцаж ирсэн өдрийг нэг хоногт тооцон томилолтын үнэмлэхэд бичигдсэн хоногоос хасаж томилолтоор ажилласан хоногийг гаргаж, тухайн үед мөрдөгдөж байгаа томилолтын зам хоногийн тарифаар үржүүлэн томилолтын зам хоногийн зардлыг олгох. Томилолтын урьдчилгаа олгосон бол баримтын бүрдлийг хангасан байдлаар тооцоо хийж, шаардлага хангахгүй баримт ирүүлсэн тохиолдолд олгосон томилолтын зардлыг албан хаагчаас суутгах.
Шалтгаан	
Байгууллагын дарга Төрийн албан хаагчдад нөхөн төлбөр олгох журам, Сангийн сайдын Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай 132 дугаар тушаалыг мөрдөж ажиллах үйлдэл, эс үйлдэл	
Үр нөлөө	
Байгууллагын дотоод хяналт сул, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах	
Дүгнэлт:	
Эрх бүхий албан тушаалтны баталсан томилолтын үнэмлэх олгох, Томилолтоор ажилласан албан хаагчдын ажлын үр дүнг үнэлж тооцоо хийх.	
Зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлж анхан шатны баримтын иж бүрдэлийг хангаж бүртгэлд тусгаж байх.	

Илэрсэн асуудал 2. Бараа материалын тайлан хөтлөлт, анхан шатны баримтын бүрдэл.	
Дотоод аудитын чиглэл: Төсөвт байгууллагын бараа материалын бүртгэл, анхан шатны баримтын иж бүрдэл хөтлөлтийг хянаж үр нөлөөг үнэлэх.	
Нөхцөл байдал: Тус байгууллагын бараа материалын бүртгэлийг 2025 оны 1-10 дугаар сарын байдлаар үзэхэд эрх бүхий албан тушаалтануудын зөвшөөрөл тэмдэглэл байхгүй, шаардах хуудас орлого, зарлагын маягт дутуу иж бүрдэлгүй бэлтгэн нийлүүлэгчийн цахим нэхэмжлэхийг үндэслэн 43,986.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж зарцуулсан байна.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар” НХМаягт БМ-1, НХМаягт БМ-2, НХМаягт БМ-3, НХМаягт БМ-5, НХМаягт БМ-6 анхан шатны маягтыг иж бүрэн үйлдэж хэвших	Байгууллагын дотоод хяналт болон, эрх бүхий албан тушаалтны хяналтгүйгээр төсвийн хөрөнгөөр эд хариуцагч, нярав эрх мэдлээ хэтрүүлэн холбогдох анхан шатны баримтгүйгээр худалдан авалт, зарцуулалт хийгдэж байна.
Шалтгаан	
Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар тушаалыг мөрдөж ажиллах үйлдэл, эс үйлдэл	
Үр нөлөө	
Байгууллагын дотоод хяналт сул, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах	
Дүгнэлт:	
Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлөөр батлагдсан төсвийн хүрээнд зохистой худалдан авалт хийх, бүртгэл мэдээлэл, тайланг тогтмол гаргаж хэвших.	
Зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.6. Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан	

ажилтан хариуцна. 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. Заалттай нийцэхгүй байна. Цаашид байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, сар бүр бараа материалын тооллого хийж тооцоо нийлэх.

5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр

Илэрсэн асуудал 1. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээ, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бодиттой байх шаардлагыг хангаж бүрэн мэдээлээгүй байна.	
Дотоод аудитын чиглэл: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Шилэн дансны тухай хуулийн 6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт; Шилэн дансны тухай хуулийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;	- Тайлант хугацаанд 27 удаагийн 314,859.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлэхээс 13 удаагийн 128,439.0 мянган төгрөгийг тухай бүр буюу 7 хоногийн дотор мэдээлээгүй байна. - Хөрөнгө мөнгө захиран зарцуулахтай холбоотой 30 удаагийн 45,510.1 мянган төгрөгийн тушаалыг мэдээлэхээс 26 удаагийн 32,787.1 мянган төгрөгийн тушаалыг тухай бүр буюу 7 хоногийн дотор мэдээлээгүй.
Шалтгаан	
Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө	
Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.	
Дүгнэлт: Тус байгууллага нь 2025 оны 3-р улирлын байдлаар шилэн дансанд 23 нэр төрлийн мэдээллийг 140 талбарт мэдээлэхээс хуулийн хугацаа хоцроож 3 талбарт мэдээлсэн, мэдээллийн үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 15 алдаа гаргасан байна	
Зөвлөмж:	
1. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;	

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны III улирлын байдлаарх төсөв санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдлын үр нөлөө, цаашид үүсэх эрсдэлийг үнэлээд дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

Аудитаар илэрсэн алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг цаглаварт хугацааны дотор ХШУДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг мэдэгдье.

7. ЗӨВЛӨМЖ

Төсвийн шууд захирагч, захирал Б.Чимэддорж танаа

Хугацаа

Зөвлөмж 1. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан, тайлангаар илэрсэн

2025 оны 12-р сарын 25-ны дотор

алдаа дутагдлыг залруулан, үр дүнг хамт олонд мэдээлж байх;

Нягтлан бодогч Б.Зул танд

Зөвлөмж 1. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;

2025 оны 12-р сарын 25-ны дотор

Зөвлөмж 2. Байгууллагын бараа материалын анхан шатны баримтын иж бүрдэлд хяналт тавьж дотоод хяналтыг сайжруулан удирдлагаар хангах

Нярав Д.Мөнхбаяр танд

Зөвлөмж 1. Ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, санхүүгийн анхан шатны баримт бүрдэлийг хангаж эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлөөр бараа материалын худалдан авалт зарцуулалтыг хийж байх;

2025 оны 12-р сарын 25-ны дотор

Зөвлөмж 2. Бараа материалын тайланг сар бүр гаргаж холбогдох анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах;

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ